



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/101

Номгон

“Ойн анхдугаар чуулган” зохион байгуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8, Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 4.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг идэвхжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, иргэд, аж ахуй нэгжийн төлөөллийн санал, санаачилгыг хэлэлцүүлж, цаашид хэрэгжүүлэх бодлогыг танилцуулах зорилгоор аймгийн “Ойн анхдугаар чуулган”-ыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.

2. Чуулган зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. “Ойн анхдугаар чуулган”-ыг үр дүнтэй зохион байгуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Сум дундын ойн анги (П.Уртнасан), Оролцогчдыг халдвар хамгааллын хэрэгслээр хангаж, дэглэм сахиулж, хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар, Хурандаа (Ж.Алтангэрэл), Мэргэжлийн хяналт газар (Н.Бямбадорж), Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОЙН АНХДУГААР
ЧУУЛГАНЫ УДИРДАМЖ**

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий зүйл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Ойн салбарын үндэсний чуулганд ойн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэл, ойжуулалт ойн нөхөн сэргээлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх гэсэн дөрвөн тодорхой асуудлаар салбар хуралдаан зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргасан. Энэ ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарын оролцоо сэдэвт семинарыг Засгийн газраас зохион байгуулж тодорхой үүрэг даалгавар өгсөн.

1.2. Чуулганы үндсэн зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар сум болон орон аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагууд, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын манлайлал, төлөвлөлт, хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцэн тодорхой чиглэл, санал, зөвлөмж гаргахад чиглэж байна.

1.3. Чуулганы тухай, оролцох бүрэлдэхүүн

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөл, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, мод тарьдаг иргэд 250-300 хүн оролцоно.

Чуулганд оролцох албан тушаалтан, байгууллагууд:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөлөл
- Ой судалгаа хөгжлийн төвийн төлөөлөл
- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга,
- Аймгийн Засаг дарга;
- Аймгийн Засаг даргын орлогч;
- Аймгийн Засаг даргын Тамгын газар

2.

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Эрүүл мэндийн газар;
- Боловсрол шинжлэх ухааны газар
- Хүнс, хөдөө аж ахуйн газар
- Ус, цаг, уур орчны шинжилгээний төв
- Сум дундын ойн анги
- Сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, мод тарьдаг иргэн, иргэний нийгмийн төлөөлөл, аж ахуйн нэгж байгууллагын тус бүр -6 хүн
- Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа;
- Их богд Байгалийн цогцолборт газрын захиргаа;
- Өлзийт мэргэжил сургалт үйлчилгээний төв
- Баянхонгор тохижилт үйлчилгээний газар
- Их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан-10 хүн
- Банкуудын төлөөлөл
- Холбоод
- Мод тарьдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг хамарсан-30, нийт 250-300 төлөөлөгч оролцоно.

2. ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Чуулганы үйл ажиллагааг нээж аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Э.Энхбат, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Ой судалгаа хөгжлийн төвийн төлөөлөл үг хэлнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газарзүй гео-экологийн хүрээлэн, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын Ойн анги илтгэл, танилцуулга тавина.

Мөн оролцогчдын хэлэлцүүлэг зохион байгуулж, Сумдын удирдлагууд, Аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, батламж гардуулах үйл ажиллагаа зохион байгуулна.

Үр, техник технологи, тарьц суулгацын үзэсгэлэн зохион байгуулна.

Чуулганыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг удирдан явуулна.

3. ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ:

3.

Баянхонгор телевиз, Мазаалай телевиз, Өнөөгийн Баянхонгор мэдээ сонин, Нээлттэй засаг - Нэг Баянхонгор мэдээллийн пэйж, Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн бүх пэйж хуудсаар олон нийтэд мэдээллийг хүргэнэ.

4. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

4.1. Салбар хоорондын уялдааг хангаж, төр иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах

4.2 Халамж, ажил эрхлэлтийн бодлого хөтөлбөртэй холбож хэрэгжүүлэх

4.3 Дэвшилтэт техник, технологийн талаар

4.4. Мэргэжилтэй боловсон хүчний судалгаа гаргаж хүний нөөцийг бүрдүүлэх талаар

4.5. Мод, жимс жимсгэнэ тариалах соёл хандлагыг бүх нийтийн үйлс болгох иргэдийн дунд сургалт сурталчилгааг зохион байгуулах талаар, соён гэгээрүүлэх ажилд уриалах;

4.7. Ногоон байгууламжаа арчлах хамгаалах салбар дундын уялдааг зөв гаргах усны эх үүсвэрийг дагаж уугуул ургамлыг нь тарих.

5. ҮР ДҮН:

- Аймгийн 20,0 сая мод тарьж ургуулах төлөвлөгөө танилцуулна
- Сумдад ойн зөвлөл байгуулах зөвлөмж өгнө
- Сум бүр өөрийн нөөц бололцоогоо судлан, үр нөөцлөх, тарьц суулгац бэлтгэх технологийн үзэсгэлэн зохион байгуулна

Аймгийн 20 сум, 105 багийн иргэдэд мод тарих, тарьц суулгац бэлтгэх, хашаандаа өөрсдийн санал санаачилгаараа эмийн ургамал, мод бут, жимс жимсгэнэ тарьдаг иргэдийг идэвхжүүлнэ.

_____оОо_____